# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 24 Улаанбаатар хот

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн Дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийг бодит мэдээллээр ханган шалгагдсан байгууллагын төсвийн эрх захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр зөвлөн туслах, санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэн, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тус алба нь 2025 оны жилийн эцсийн байдлаар батлагдсан орон тоогоор 9.5 хүний бүрэлдэхүүнтэй нийт 2259 хүн өдөр ажиллахаас 32 хүн өдөрт албаны дарга, 125 хүн өдөрт 1 дотоод аудиторын орон тоо дутуу, 197 хүн өдөрт ээлжийн амралттай нийт 1905 хүн өдөр ажиллаж санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын чиглэлээр хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

## ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**2.1. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтын талаар:**

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан Дотоод аудитын албаны 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2025 онд нийт 44 байгууллагад төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 44 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж төлөвлөгөөний биелэлт 100.0%-тай байна.

Төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтын талаар

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан 2025 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд нийт 35 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийхээр төлөвлөж гүйцэтгэлээр СХШУТ/2025-01 дүгээр удирдамжийн хүрээнд нийт 12 өрхийн эрүүл мэндийн төв /Ариун-Энэрэл, Одонт манал, Эхэн босго, Энх-Элбэрэл, Арвин мэнд, Гурванжаргалхайрхан, Гурван тэрх, Мичид асрал, Өлзийт манал, Энх-Ачит, Гурванцуур, Батцэцэн/ -ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаа, СХШУТ/2025-03 дугаар удирдамжийн хүрээнд нийт 18 цэцэрлэгийн /55, 117, 125, 170, 188, 214, 215, 244, 252, 259, 261, 264, 270, 271, 286, 316, 328, 330 / 2024 оны

жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, СХШУТ/2025-06 дугаар удирдамжийн хүрээнд нийт 5 ерөнхий боловсролын сургууль /104, 124, 143, 151 дүгээр сургууль, Насан туршийн суралцахуйн төв/-ийн нийт 35 байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Сангийн сайдын баталсан 2025 оны СХШХ/06 дугаар "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба, аймгуудын газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажилгаанд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэх" нэгдсэн удирдамж, дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан СХШУТ/2025-02 дугаар удирдамжийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Газар зохион байгуулалтын нэгдүгээр, хоёрдугаар албаны 2023, 2024 оны үйл ажиллагаа, газрын төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлт, өглөг, авлагын байдлыг хамруулан санхүүгийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж, шалгалтын танилцуулгыг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

Төлөвлөгөөт дотоод аудитын талаар:

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан ДАУТ/2025-07 дугаар удирдамжийн хүрээнд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харъяа орон нутгийн 6 байгууллага /Жаргалант тосгоны Захирагчийн Ажлын алба, Худалдан авах ажиллагааны алба, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл сургалтын төв, Усан спорт сургалтын төв, Амралт цогцолборын газар, Жаргалант тосгоны Соёлын ордон/-ын 2024 оны үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод аудитыг гүйцэтгэж ажиллав.

2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан дүүргийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн зарцуулалтад Нийслэл дэх Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн аудит хийсэн тул хяналт шалгалтыг давхцуулахгүйгээр, Дэд бүтэц хөгжлийн алба ОНӨААТҮГ-ын 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийх гүйцэтгэлийн дотоод аудитыг дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд Засаг даргын шийдвэрийн дагуу аудит, хяналт шалгалтыг түр хугацаагаар хойшлуулсан болно.

Нийцлийн аудитын талаар:

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан ДАТ/2025-07 дугаар удирдамжийн хүрээнд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харъяа орон нутгийн 6 байгууллага /Жаргалант тосгоны Захирагчийн ажлын алба, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл сургалтын төв, Худалдан авах ажиллагааны алба, Амралт цогцолборын газар, Усан спорт сургалтын төв, Сонгинохайрхан дүүргийн Соёлын ордон/-ын 2024 оны захирамжлалын баримт бичигт,

мөн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан СХШУТ/2025-04 дүгээр удирдамжийн хүрээнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтын талаар

Нийслэлийн Дотоод аудитын албаны 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 2/91 дугаартай албан бичиг, "Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06/6146 дугаартай албан бичиг, Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан СХШУТБ/2025-05 дугаар удирамж "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бохир ус соруулалт, тээвэрлэлттэй холбоотойгоор гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай"-ийн хүрээнд төвийн шугамд холбогдоогүй бохир ус соруулдаг орон нутгийн 6 байгууллага, 18 сургууль, 40 цэцэрлэг нийт 64 байгууллагын 2023-2025 оны бохир ус соруулалт, түүний тээвэрлэлийн байдалд, мөн СХШУТБ/2025-08 дугаар удирдамжийн хүрээнд СХД-ийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төв, 26 сургууль, 47 цэцэрлэг, нийт 76 байгууллагад 2024-2025 онд орон нутгийн төсвөөс хуваарилсан урсгал засварын зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг тус тус гүйцэтгэлээ.

**2.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагчийн акт, албан шаардлагын биелэлт:**

Тайлант хугацаанд 44 байгууллагад гүйцэтгэсэн санхүүгийн хяналт шалгалт дотоод аудитаар нийт 39,824,567.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж нийт 8 байгууллагын албан тушаалтанд 7,823.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн бөгөөд актын барагдалт 43.1 хувьтай, санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар нийт 46 байгууллагад холбогдох 17,132,470.0 мянган төгрөгийн зөрчилд санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагчийн албан шаардлага хүргүүлж, албан шаардлагын биелэлт 100.0. хувьтай, нийт давхардсан тоогоор 80 байгууллагад холбогдох 4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч биелэлт 100 хувьтай байна.

**2.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан талаар:**

Сонгинохайрхан төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа нийт 117 байгууллага (орон нутгийн байгууллага 12, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3, сургууль 29, Насан туршийн суралцахуйн төв 1, цэцэрлэг 71, Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв 1), төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй 26 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 143 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар, улирлаар хяналт

шалгалтыг гүйцэтгэн, 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1, 2, 3 дугаар улирлын хяналт шалгалтын тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж ажиллалаа.

**2.4. Дүүргийн Дотоод аудитын хорооны үйл ажиллагаа:**

Сонгинохайрхан төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харъяа нийт 117 байгууллага (орон нутгийн байгууллага 12, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3, сургууль 29, Насан туршийн суралцахуйн төв 1, цэцэрлэг 71, Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв 1), төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй 26 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 143 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар, улирлаар хяналт шалгалтыг гүйцэтгэн, 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1, 2, 3 дугаар улирлын хяналт шалгалтын тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж ажиллалаа.

**2.5. Зөвлөн туслах ажлын чиглэлээр:**

Албаны даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн "Сонгинохайрхан дүүргийн Дотоод аудитын албанаас төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хуваарь"-ийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд Толгойт, Төвийн, Өнөр бүсийн нийт төсвийн 13 байгууллагын 53 албан хаагчдад, Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан Дотоод аудитын албаны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу төлөвлөгөөт 42, төлөвлөгөөт бус 1 байгууллага, 2 сэдэвчилсэн хяналт шалгалтад хамрагдсан нийт 140 байгууллагын удирдлага, санхүү бүртгэлийн болон дотоод хяналтын нэгжийн ажилтнуудад хяналт шалгалтын явцад төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Зөвлөн туслах ажлыг удирдлага, санхүү бүртгэлийн ажилтнуудад дараахь чиглэлээр зохион байгууллаа. Үүнд: Санхүү төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт, удирдлагын захирамжлалын баримт бичгийн боловсруулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, бараа материалын үнэн зөв байдал, тооцоо бодолт, зарцуулалт хадгалалт, хамгаалалт, төсөв, төсөл хөтөлбөр, хандив, зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон үндсэн хөрөнгийн бэлтгэлт, зориулалт, зарцуулалт, Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа зэргийг хамруулаа.

Зөвлөн туслах ажлыг нийт 13 байгууллагын 53 албан хаагчдад хүргэж ажиллалаа.







## ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТУУДЫГ ТАЙЛБАРЛАН ТАНИУЛАХ, СУРТАЛЧИЛАХ ТАЛААР

Тус албаны чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд "Авлигатай тэмцэх" үндэсний хөтөлбөр, "Жендерийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, албаны Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, төрийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах, байгууллагын чанарын үнэлгээний болон дотоод хяналтын багийн, баримт нягтлан шалгах комиссын, эцэг эхийн зөвлөлийн болон бүсүүдэд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Авлигатай тэмцэх (2023-2030он) үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус албаны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг нийт 5 зорилго, 13 заалт бүхий боловсруулан албаны даргаар батлуулж нийт албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг 2025 онд 97.6%-тай хангаж ажиллалаа.

"Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 онд 5 зорилт 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулан албаны даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2025 онд төлөвлөгөөний хэрэгжилт 96.9%-тай биелсэн бөгөөд биелэлтийн тайланг гарган Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэст хүргүүлж ажиллалаа.

2025 онд Монгол Улсын хууль 7, Улсын Их Хурлын тогтоол 2, Ерөнхийлөгчийн зарлиг 2, Засгийн газрын тогтоол 3, Ерөнхий сайдын албан даалгавар 3, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол 1, Нийслэлийн Засаг даргын захирамж 1 Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын албан даалгавар 1, захирамж 15, нийт дээд газраас 35 хууль тогтоомж, тогтоол шийдвэр ирсэн бөгөөд нийт албан хаагчдад танилцуулан хяналтанд авч, биелэлтийг гаргаж ажиллалаа.

Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт 101.1%-ийн биелэлттэй байгаа бөгөөд тайланг дүүргийн Засаг даргын Тамгын газарт хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан болно.

Тус албаны даргын 2025 оны А/36 дугаар тушаалаар албаны дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-г 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос 2025 онд "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулиар сургалт зохион байгуулж, байгууллагын цахим хуудсанд хууль тогтоомжийг сурталчлах замаар албан хаагчид болон иргэдэд нөлөөллийн ажил зохион байгуулан ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах зорилгоор Төрийн албаны манлайлал нийслэлийн бүсийн зөвлөгөөнд хамруулсан. Мөн тус албаны нийт албан хаагчдад Ахлах дотоод аудитор Ш.Болормаа "Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, цаг ашиглалтыг дээшлүүлэх" талаарх сургалт зохион байгуулсан.

Тус албаны төрийн албан хаагчийн болон хүний нөөцийн 6 төрлийн судалгааг 2025 онд шинэчлэн гаргаж, нийт 8 албан хаагчийн хувийн хэргийн баяжилтыг хийж, хүний нөөцийн системд баталгаажуулалтыг хийсэн.

2025 онд тус албаны цахим хуудсаар дүүргийн хэмжээнд зохион байгуулагдсан шинэ шинэлэг мэдээ, мэдээлэл дүүргийн цахим хуудсаар дамжин хүргэгддэг тухайн өдрийн онцлох үйл явдлын болон дүүргийн хороодын хог ачилтын хуваарь бусад алба хэлтсээс зохион байгуулж буй ажил үйлчилгээний зарлал, аяны мэдээллүүд зэрэг 93 нэр төрлийн мэдээ, фостер, реел, богино хэмжээний бичлэг зурган мэдээллийг бэлтгэн байршуулж тухайн онд шинэчлэгдэн мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, түүний өөрчлөлт, бусад алба хэлтсээс зохион байгуулагдсан үйл ажиллагааны цаг үеийн мэдээ мэдээллийг шэйр хийн албаны цахим хуудсаар түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж 1680 гаруй иргэдэд мэдээлэл түгээн ажилласан байна.

Бүтээн байгуулалтын жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сонгинохайрхан дүүрэгт 2025 онд хийгдэж буй бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын талаар тус албаны албан ёсны 3 цахим хуудсанд 10 мэдээлэл байршуулан сурталчилж, 230 иргэнд хүргэсэн байна.

## .ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2025 онд 438,994.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас хүлээгдэж буй гүйцэтгэлээр 438,994.2 мянган төгрөгийг зарцуулсан дүнтэй байна. Төсвийн гүйцэтгэлийн болон нийгмийн даатгал, татварын тайлан, сар улирлын мэдээ, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж ажиллалаа. Мөн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өөрчлөлт /зөрчил/-гүй гарсан байна.

Байгууллагын даргын 2025 оны А/17, А/30 дугаар тушаалаар тус албаны эд хөрөнгийн тооллогын комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, тооллогыг 2025 оны эхний хагас жил, жилийн эцсээр зохион байгуулж, тооллогыг бодитоор тоолж, чанартай гүйцэтгэн тайланг илтгэх хуудсаар гарган баталгаажуулж, албаны дарга, байгууллагын дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж ажиллалаа.

Тус албаны Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2025 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан албаны даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд 2025 онд төлөвлөгөөний биелэлт 100.0 хувьтай байна. Мөн хөрөнгийн нэр, ангиллын код, бүртгэлийн дугаар, марк, хүчин чадал, хэмжих нэгж, биет хэмжээ, үйлдвэрлэсэн улсын нэр, үйлдвэрлэсэн огноо, ашиглалтад орсон огноо, ашиглах хугацаа, тоо, нэгжийн үнэ, санхүүгийн тайлант тусгагдсан дүн зэрэгт хяналт тавин ажиллалаа. Тайлант хугацаанд тус зөвлөл нь 4 удаа хуралдаж, тус албанд шаардлагатай эд хөрөнгийг худалдан авах болон ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасч, актлах саналыг байгууллагын удирдлагад танилцуулан, удирдлагын шийдвэрээр холбогдох байгууллагад саналыг хүргүүлж ажилласан.

Албан хаагчдын ая тухтай ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор албан хаагчдын ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай, үзүүлэлт сайтай компьютер, техник хэрэгслээр бүрэн хангаж, тус албаны 2025 оны батлагдсан төсвөөс нийт 16,900.9 мянган төгрөгийн зарцуулсан болно.

Тус алба нь 2025 оны 11 сарын байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 160 мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн байршуулж, улирлын шилэн дансны тайланг хуулийн хугацаанд нь илгээж ажиллалаа.

## ТАВ. СУРГАЛТЫН ТАЛААР

Албаны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг 2025 онд нийт 3 зорилт 11 арга хэмжээний хүрээнд зохион байгуулахаар боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 98%-тай байна.

2025 онд төсвийн байгууллагуудын шууд захирагчид болон санхүү бүртгэлийн

ажилтнуудад "Аудитын шалгалтын явцад илэрч байгаа зөрчлүүд, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах талаар", дотоод хяналтын ажилтнуудад "Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах арга зүй" сэдвээр нийт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 300 гаруй албан хаагч хамрагдсан байна.

**Нэг. Дотоод аудитын албаны төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадвар, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэн мэргэшүүлэх, төрөл бүрийн сургалтад хамруулах зорилтын хүрээнд:**

025 оны 05 дугаар сарын 28,29-ны өдрүүдэд Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэгийн байнгын хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал" сэдэвт нийслэлийн сургалт, зөвлөгөөнд тус албаны ахлах дотоод аудитор Ш.Болормаа, Г.Энхзул нар оролцсон.





1.2 Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн хооронд цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан 120 цагийн аудиторын сургалтад тус албаны дотоод аудитор М.Гүнчинсүрэн, Б.Дуламжав, Д.Гэрэлт-Од, Г.Жаргалмаа нар




хамрагдаж тус хөтөлбөрийн шалгалтыг амжилттай өгч тэнцэж гэрчилгээ авсан.

1.3 Тус албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд батлагдсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй сургалтын гэрээ байгуулан, тус төвийн Туяа багштай хамтран албаны 7 албан хаагчдад Монгол бичгийн 24 цагийн сургалтыг амжилттай явуулж дуусгасан.





1.4 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Сангийн яамнаас Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба, аймгуудын газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын үйл ажиллагаанд хийх нэгдсэн хяналт шалгалттай холбоотой мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулсан.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаярын удирдан явуулсан цахим сургалтад албаны нийт 6 дотоод /ахлах/ аудитор хамрагдсан.




1.5 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Баянгол дүүргийн Дотоод аудитын албанаас санаачлан Монгол Улсын Сангийн яамтай хамтран 13 яам, 21 аймаг, 9 дүүрэг, нийслэлийн Дотоод аудитын нэгж, Гааль, Татварын ерөнхий газрын дэргэдэх Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын 250 орчим албан хаагчдад "Дотоод аудитын үйл ажиллагааны стандарт, арга зүй" сэдэвт үзүүлэх сургалтад тус албаны дарга болон 5 дотоод /ахлах/ аудитор хамрагдсан.

Энэхүү үзүүлэх сургалтад Сангийн яамны Санхүүгийн хяналт эрсдэлийн удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаяр, Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Г.Отгонбаяр, Баянгол дүүргийн Дотоод аудитын албаны дарга Н.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын ерөнхийлөгч, Баянгол дүүргийн Дотоод аудитын хорооны хөндлөнгийн гишүүн Д.Нацагдорж, IIA Mongolia Chapter, Удирдах зөвлөлийн гишүүн, Монгол банкны Дотоод аудитын газрын захирал А.Шижирмаа нарын болон бусад албаны хүмүүс







оролцож, сургалтад оролцсон хүмүүст мэдээлэл хүргэсэн.

1.6 2025 оны 06 дугаар сарын 9-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Удирдлагын академитай хамтран "Гэрээний үүрэг, төрөл, онцлог" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Дүүргийн төрийн захиргааны байгууллагууд болон орон нутгийн өмчит байгууллагуудын Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, гэрээний эрх зүйн зохицуулалт хариуцсан ажилтнуудад "Гэрээний үүрэг, төрөл, онцлог" сэдэвт чадавхижуулах сургалтыг Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш С.Ганцэцэг удирдан явуулсан бөгөөд тус албаны 2 албан хаагч хамрагдсан.






1.7 2025 оны 06 дугаар сарын 12 ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар Авилгатай тэмцэх газартай хамтран дүүргийн төрийн байгууллагуудын албан хаагчдад Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт хэлэлцүүлэгийн зохион байгуулсан.

Энэ сургалтыг Авилгатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Б.Тэрбиш, Көүчлаб сургалтын төвийн багш Б.Бат-Отгон нар удирдаж явуулсан бөгөөд сургалтад тус албаны дотоод аудитор М.Гүнчинсүрэн, Б.Дуламжав, Д.Гэрэлт-Од, Г.Жаргалмаа нарын 4 албан хаагч хамрагдсан.





Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг"-ийг орон даяар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Архивын хэлтэс хамтран зохион байгуулсан Архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын




архивын үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт, аргачлал сэдэвт сургалтад тус албаны 6 албан хаагч хамрагдсан.

1.10 Монгол Улсын Сангийн яам, Азийн Хөгжлийн банк (АХБ)-тай хамтран "Улсын салбарын дотоод аудиторуудыг чадавхжуулах, олон улсын туршлага солилцох зөвлөгөөн"-ийг 2025 оны 11 дүгээр сарын 13,14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү сургалтад тус албаны Ахлах дотоод аудитор Ш.Болормаа, Г.Энхзул нар танхимаар, цахимаар 3, нийт 5 дотоод аудитор хамрагдсан.







Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв, Таван толгой ХХК, Дижитал инфосек ХХК хамтран 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын зуухны бүрэн бүтэн байдал, галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, Хотула аппликейшний үйл ажиллагаа, агаар бохирдуулагч хориглосон эд зүйлс шатааж буй эсэхэд хяналт шалгалт хийх, судалгаа гаргаж, зөвлөмж хүргүүлэх ажлын хүрээнд хяналт шалгалт хийж ажиллах албан хаагчдад зохион байгуулсан сургалтад тус албаны 6 албан хаагч хамрагдлаа.





**Хоёр. Албан хаагчдын төсөв санхүү, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

2.1 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр “Архив, албан хэрэг хөтлөлт, e-Doc систем ашиглалт” сэдвээр тус албаны архив, бичиг хэрэг, нярав С.Мөнхцэцэг албан хаагчдад сургалт зохион байгуулсан.





2.2. Тус албаны нийт албан хаагчдад ахлах дотоод аудитор Ш.Болормаа “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, цаг ашиглалтыг дээшлүүлэх” талаарх сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдөр зохион байгуулж, албан хаагчид идэвхтэй оролцлоо.







**Гурав. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагын, төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй төрийн бус өмчийн өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйгээр хангах зорилтын хүрээнд**

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйгээр хангах зорилтын сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж, албаны дарга Д.Төмөрбаатар, ахлах дотоод аудитор Ш.Болормаа нар “Аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрч байгаа зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудал”” сэдвийн хүрээнд сургалт мэдээлэл хийлээ. Сургалтад нийт 280 гаруй төсөвт байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнууд хамрагдсан байна.







3.2 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дотоод хяналтын нэгжийн шинээр томилогдсон албан хаагчдад Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын танилцуулга, Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтад нийт 58 дотоод хяналтын нэгжийн албан хаагчид хамрагдсан.








3.3 Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор дүүргийн ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг нь сайжруулах, эрчимжүүлэх, албан хаагчдын дунд сурталчлах "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг үр дүнтэй, олон нийтэд нээлттэй, зохион байгуулан тус албаны бүс хариуцсан аудиторууд хяналт тавьж хамтран зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан. Нээлттэй хаалганы өдөрлөгийн арга хэмжээг ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын нийт 56 байгууллага зохион байгуулж, 1330 гаруй албан хаагч, 3440 эцэг эх, асран хамгаалагчид тус арга хэмжээнд идэвхтэй оролцсон.

## ЗУРГАА.БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөө, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаал, байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд тус албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мөн дүүргийн Засаг даргатай хариуцлагын гэрээ байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Тус албаны 2024 онд үүссэн албаны даргын гаргасан нийт 53 захирамжлалын баримт бичгийг "Archive eDoc" системд цахимжуулж, нягтлан шалгалтын ажлыг хийж илгээсэн болно.

2025 онд тус албаны даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 27, боловсон хүчний чиглэлээр Б тушаал 7 гаргасан бөгөөд захирамжлалын баримт бичгийн төслийн хууль, эрх зүйн талаас хууль, эрх зүйн мэргэжилтэн хянаж захиргааны актын хувийн хэргийг тогтмол хөтөлж байна.

2025 онд албан хэрэг хөтлөлтийн edoc.ulaanbaatar.mn цахим системээр нийт 276 бичиг бүртгэгдсэн үүнээс (хариутай 14, хариугүй 262) албан бичгийг хугацаанд нь 100% шийдвэрлэж, баримт бичгийн эргэлтийн мэдээг 14 хоног тутам гарган албаны даргад танилцуулан ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар тус албаны албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1.79%-тай, хугацаа хэтэрч хаагдсан болон зөрчилтэй албан бичиг байхгүй болно.

Тус албаны удирдлага болон байгууллагын Баримт нягтлан шалгах комисс нь ERP дотоод удирдлагын системийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн дэд цэсийн бүртгэл, үр дүнг тооцон хяналт тавин ажиллаж байна. 2025 онд нийт 8 өргөдөл хүсэлт ирсний иргэдээс 1 өргөдөл хүсэлт, албан хаагчдаас 6 өргөдөл хүсэлт ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэсэн болно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа 9 хоног 11 цаг 30 минут байна.2025 онд тус албаны архиваас лавлагаа мэдээлэл авах хүсэл ирээгүй байна.

Байгууллагын архивт нийт албан хаагчдаас 2024 оны үйл ажиллагааны үр дүнд үүссэн нийт 85 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивын хадгаламжийн санд хүлээн авсан бөгөөд үүнээс 70 жил хадгалах 3, түр хадгалах 62, байнга хадгалах 34 хадгаламжийн нэгж байна. Албаны даргын захирамжлалын болон хяналт шалгалтын 16 хадгаламжийн нэгжийг PDF файлаар DVD-д буулган 4,319 mb цахим баримтыг архивын данс бүртгэлд хүлээн авсан.

2025 онд нийт 8 өргөдөл хүсэлт ирсний иргэдээс 1 өргөдөл хүсэлт, албан хаагчдаас 7 өргөдөл хүсэлт ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэсэн болно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа 9 хоног 11 цаг 30 минут байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд шаардлагатай материал, тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан бөгөөд, 2025 онд принтер 550.0 мянган төгрөг, сэйф мянган төгрөг, скайнер 2,199.8 мянган төгрөгөөр худалдан авч Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан.

Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан "...төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна" гэсэн заалт 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Боловсролын сайдын 2025 оны 01/377 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэж байгаа 5 нэр төрлийн 500 ширхэг хэвлэмэл хуудсыг монгол бичгээр хэвлүүлэхээр Нийслэлийн Архивын газарт цахим захиалга илгээж, албаны даргын тушаал-100 ширхэг, А5 албан бичгийн хэвлэмэл хуудас-50 ширхэгийг тус тус хэвлүүлэн албан хэрэгцээнд ашиглаж байна.

Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралд хуваарийн дагуу оролцож, нийслэл, дүүргийн удирдлагаас өгсөн мэдээлэл, үүрэг даалгаврыг албан хаагчдад танилцуулан үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр гаргаж холбогдох хэлтэст хүргүүлэн ажиллалаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар албаны шуурхай хурлыг нийт удаа зохион байгууллаа.

Тус албаны төрийн албан хаагчийн болон хүний нөөцийн 6 төрлийн судалгааг төрөлжүүлэн 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн гаргаж, нийт 8 албан хаагчийн хувийн хэргийн баяжилтыг хийлээ.

Албаны даргын 2024 оны А/18 дугаар тушаалаар Чанарын үнэлгээний багийг 3, А/19 дугаар тушаалаар Дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Чанарын болон дотоод хяналтын 2025 оны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд 2025 онд Чанарын үнэлгээний төлөвлөгөөний биелэлт 100.0%-тай, Дотоод хяналтын төлөвлөгөөний биелэлт 99.4%-тай байна.

Тус албаны Баримт нягтлан шалгах комиссын 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 зорилт, 6 арга хэмжээ зохион байгуулахаар батлуулж, хэрэгжилтийг 100.0%-тай хангаж ажилласан. Тайлант хугацаанд БНШК-ын хуралдааныг 2 удаа хуралдуулан хуралдаанаар 5 асуудлыг авч хэлэлцэн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2025 онд төрийн болон орон нутгийн байгууллагуудын санхүү, бүртгэлийн ажилтнуудын дунд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа явуулж, давхардсан тоогоор сэтгэл ханамжийн судалгаанд нийт 128 санхүү, бүртгэлийн

ажилтнууд хамрагдлаа. Энэ судалгаагаар тус албанаас цахим орчинд цаг үеэ олсон мэдээлэл түгээдэг, цахим хуудаснаас хэрэгтэй мэдээллээ олж авдаг, албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, санхүүгийн хяналт шалгалт, Дотоод аудитын үйл ажиллагааг судалгаанд оролцогчдын 98.6% нь хууль, тогтоомжийн хүрээнд шударга явагддаг гэж хариулсан байна.

2013-2025 онуудын төсвийн байгууллагуудын шинэчилсэн бүртгэл, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хийгдсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын чиглэлээр төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэн 2025 онд шалгалтад хамрагдсан нийт 43 байгууллагын мэдээллийг нэгтгэж мэдээллийн санд оруулсан.

Албаны "Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө"-г 5 зорилт 16 арга хэмжээ зохион байгуулахаар боловсруулан албаны даргаар батлуулан хэрэгжилтийг хангах ажиллаж байна. 2025 онд төлөвлөгөөний биелэлт 90.2%-тай байна.

Тус албаны архив, бичиг хэргийн ажилтан, нярав С.Мөнхцэцэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнагдсан бөгөөд тус албаны "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу байгууллагын 2025 оны батлагдсан төсвөөс 300.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Мөн дотоод аудитор Б.Дуламжавыг СХД-ийн ИТХ-ын Хүндэт тэмдэг, дотоод аудитор Д.Гэрэлт-Одыг дүүргийн Засаг даргын Хүндэт тэмдэгээр шагнуулахаар уламжилж, шагнуулсан болно.

## ДӨРӨВ. БУСАД АЖЛЫН ТАЛААР

онгол Улсын Засгийн газрын "Түүхий нүүрсний хэрэглээг хориглох тухай" 2018 оны 62, 2022 оны 223 дугаар тогтоолуудын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх удирдамжийн хүрээнд нийслэлийн Засаг даргын 2025 оны А/33 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай" 2025 оны А/20 дугаар захирамжуудыг үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 18-19 ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 06 дугаар хорооны нийт 1250 аж ахуйн нэж байгууллага, айл өрхийн түлшний хэрэглээнд хяналт тавин ажиллаж дүүргийн шуурхай штабт тайлан мэдээг хүргүүлэн ажилласан.

025 онд Нийслэл, дүүргийн удирдлагаас гаргасан холбогдох захирамж, шийдвэрийн дагуу хуваарьт хороо болох Сонгинохайрхан дүүргийн 41-р хорооны нутаг дэвсгэрт "Бүх нийтийн их цэвэрлэгээ"-г нийт 9 удаа зохион байгуулж, хийсэн ажлын тайлан мэдээг хугацаанд нь дүүргийн Агаарын бохирдолтой тэмцэх тасагт хүргүүлж ажиллалаа.

ус албаны "Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт

илрүүлэгийн багц шинжилгээнд бүрэн хамруулж, байгууллагын 2025 оны батлагдсан төсвөөс 1,650.0 мянган төгрөгийг зарцуулсан болно. Мөн тус дүүргийн "Энхийн өргөө" өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран тус албаны нийт албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг, биеийн индекс оношилгооны аппаратаар иж бүрэн оношилж, албан хаагчдад эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

үүргийн Засаг даргын гаргасан "Иргэдийн ундны ус зөөвөрлөх, хадгалах савыг сольж, шинэчлэх" санаачлага, уриалгын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хорооны зорилтод бүлгийн өрхийн ундны усны савыг шинэчлэх зорилгоор зориулалтын ган никель 15 ширхэг савыг 9 дүгээр хорооны Засаг дарга Л.Бямбадоржид хүлээлгэн өглөө.

онгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын дагуу жил бүрийн гуравдугаар сарын 4 дэх долоо хоногийн пүрэв гарагт улс орон даяар гамшгийн аюулын зарлан мэдээлэх дуут дохиогоор ажиллах гамшгийн дадлага сургуулилтын арга хэмжээ зэрэг нийслэл дүүргээс зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байна.

онгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрийн Улаанчулуутын хур хогийн цэгийг цэвэрлэсэн талбайн ойн зурвас, Сонгинохайрхан дүүргийн 33-р хороонд байрлах "Цагдаа толгой"-д хаврын мод тарих арга хэмжээнд хамт олноор бүрэн хамрагдан хуваарилагдсан газартаа 28 ширхэг хайлаас улиас тарьсан.

үүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 4 чиглэл 23 заалттайгаар боловсруулан албаны даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 онд төлөвлөгөөний биелэлт 95%-тай байна.

## ДОЛОО. ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЛААР

Байгууллагын гүйцэтгэлийн тайланг 2025 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг 69.0%-тай, жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг 98.4%-тай ханган ажилласан бөгөөд байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний биелэлтийг гарган Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүллээ.

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, ажлын байранд тогтвортой ажиллах нөхцөл боломцоог дээшлүүлэх ажлын хүрээнд 2025 онд Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан Аудиторын эрх олгох сургалтад тус албаны 4 аудитор хамруулж нийт 2,400.0 мянган төгрөгийн сургалтын зардлыг төсвөөс төлж мэдлэг мэргэшлийг дээшлүүллээ. Мөн 1 албан хаагч магистрын сургалтад хамрагдаж байна.

